

Монгол болон Японд хадгалагдаж байгаа Их Юань улсын үед хамаарах зэр зэвсгийн харьцуулсан судалгаа

Сосорбарамын Хүрэлсүх^{1,*}

Товч агуулга: Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсын нэг Их Юань улсын түүхийг далайцтайгаар судлан шинжлэхэд Хубилай сэцэн хааны цэрэг Японд довтолсон усан флоттой холбогдох түүхэн баримтаас гадна археологийн олдвор, эх хэрэглэгдэхүүн ихээхэн чухал болохыг Япон улсад сүүлийн үед хийсэн далайн археологийн судалгаа, хурал зэргээс харж болно. Тиймээс энэхүү өгүүлэлд Монгол болон Японд хадгалагдаж байгаа Их Юань улсын үед холбогдох зэр зэвсгийн зарим олдворуудыг харьцуулан авч үзэх оролдлого хийсэн бөгөөд судалгааны товч үр дүнг нийтлүүлж байна. Судалгааг хийхдээ манай улсын нутгаас олдсон Их Юань улсын (1264-1368 он) үед холбогдох ¹⁴C-ийн он цагтай булш оршуулгын дурсгалаас илэрсэн зэр зэвсгийн эх хэрэглэгдэхүүнийг Япон улсад хадгалагдаж буй олдворуудтай харьцуулан авч үзлээ.

Түлхүүр үг: Монгол дайчдын зэр зэвсэг, Их Юань улс, Монгол, Япон

Удиртгал

XIII-XIV зууны үед дэлхийн түүхэнд Их Юань улсаар төвлөсөн Монголын эзэнт гүрэн мандсан нь Зүүн хойд Азийн Монгол нутагт ээлж дараалан оршин тогтнож байсан Хүннүгээс эхтэй эртний нүүдэлчин улс, гүрнүүдийн улс төр, цэрэг зэвсгийн уламжлал, хөгжил, хувьслын үр дүн бөгөөд үе үеийн манлайлагчдын удирдан зохион байгуулах авъяаслаг чадвар, хатуу чанд удирдлага, цэрэг армийн зэвсэглэл, нүүдэлчдийн тэсвэр хатуужил, байлдах арга, ухаанд оршин байв.

“Монголын нууц товчоо” зэрэг эртний сурвалж бичигт өдөж хөдөлгөх, нуур байрт байлдах, цүүц хатгаа хатгах, алгинчлах, өлөмлөх, дэрлэх, бүгэх, тойрох, шивээлэх, хороолох, хүрээлэх, нүүр дээр нь асгах, харгана зорчил зорчих, нохой хэрэл хэрэх, нуман түлхүүр байр хийх, бух сэжүүр байр хийх, сацсан одны жагсаал, чонын алхаа гэх мэт байлдааны тактикийг хэрэглэдэг байжээ (Базарсүрэн 2006: 83). Монгол дайчдын гол төрөл нь хөнгөн болон хүнд морин цэрэг бөгөөд цэргүүд нь хөө хуяг өмсөж, нум сум агсаж, сэлэм, биеэ халхлах бамбай барина. Ойрын тулаанд балтага бүхий нэг талдаа иртэй, үл ялих махир төмөр сэлэм, шиддэг жад, байлдааны хутга, сүхээр зэвсэглэдэг. Хотын хэрмийг эвдэхэд оньсон дүүгүүр, галт сум, чулуун сум, үүлэн шат, чулуу шидэгч, хөшгөн утаа зэргийг ашиглахын зэрэгцээ гол мөрний гольдрилыг өөрчилж усанд авахуулах гэх мэт олон арга хэрэглэдэг байсан тухай судлаачид өгүүлдэг

(Худяков 2007: 28-37, Базарсүрэн 2006: 128-137, Josef Kreiner 2005: 328).

Их Юань гүрний үеийн монгол дайчдын үндсэн зэвсэг нум сум бөгөөд модон эх бие дээр хэд хэдэн хэсгээс бүрдсэн эвэр ясан наалттай, алсын тусгалтай, морин цэрэгт тохирсон нарийн хийц бүхий зүймэл нумыг, үүрэг зориулалтаараа олон төрлийн зэвтэй сумнуудын хамт хэрэглэж байжээ. Ийм нум нүүдэлчдийн ертөнцөд хүннү болон түүнээс өмнөх үед үүссэн бөгөөд монголчуудын байлдан дагуулалын үед Евразийн хээр талын бүс нутгийн ард түмний дунд тархан “монгол нум” хэмээн алдаршжээ (Эрдэнэ-Очир 2014: 105).

Их Юань гүрний үед холбогдох булш, оршуулгын дурсгал өнөөгийн Монгол нутгаас багагүй олдсон байдаг бөгөөд тэдгээр булшнаас зэр зэвсэгтэй холбогдох нум сум, сэлэм, хутга, жад, хөө хуяг бүхий эд өлгийн зүйлс илэрсэн байдаг. Тиймээс Монгол болон Японд хадгалагдаж буй Их Юань гүрний үеийн зэр зэвсгийн зарим олдворуудыг харьцуулан авч үзэх оролдлого хийсэн юм.

Судалгааны хэлэлцүүлэг

Төмөр дуулга. Монгол дайчдын зэр зэвсгийн нэгэн чухал төлөөлөл нь төмөр дуулга юм. Монгол улсын нутаг дэвсгэр дээрх булш, оршуулгын дурсгалаас Их Юань гүрний үед хамаарах төмөрлөг дуулга одоогоор илэрч олноогүй байгаа ч Өвөр Монголын нутгаас цуглуулгаар хэд хэд олджээ (Зураг 1). Эдгээр дуулгыг харьцуулан үзвэл 4 болон 6 тал бүхий бөмбөгөр оройтой, орой дээрээ нарийн босоо төмөртэй ба богино болон уртлаг хүрээг доош нь налуу загвартайгаар

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн, Дундад зууны судалгааны салбар

* Холбоо барих зохиогч: khurelsukh_s@mas.ac.mn
<https://orcid.org/0000-0003-2324-1010>



Зураг 1. а. Өвөр Монголын музейн цуглуулгад хадгалагдаж буй Юань гүрний үеийн төмөр дуулга, б. Өвөр Монголоос олдсон Юань гүрний үеийн төмөр дуулга, с. Тунляо орчмоос олдсон төмөр дуулга

хийсэн байдлаараа ижил төстэй байна.

Хубилай хаан цэрэг дайны үйл ажиллагаагаа Японд төвлөрүүлж, 1274 онд Цушима, Ики-ийн тулалдаануудын дараа Кюүшюү-гийн хойд эргийн Мацуура, Хирадо, Такашима, Нокодо арлуудыг 900 орчим хөлөг онгоцоор довтолжээ (Конагая Юки 2020: 18). Он цаг улиран өнгөрөх тусам Такашима арлын эрэг, усан дотроос Их Юань гүрний үеийн дайчдын зэр зэвсэгтэй холбогдох цөөнгүй зүйлс олджээ. Одоо эдгээр тэсэрдэг сум, чулуун сум, төмөр дуулга, сэлэм зэрэг зүйлс нь Мацуура хотын түүх, ардын аман зохиолын Такашима музейд хадгалагдаж буй ажээ. Эдгээрээс төмөр дуулга бидний анхаарлыг татах бөгөөд уг дуулга тэнгисийн ёроолд он удаан байж, элс шаврыг шингээн хөөсөн учир ийм байдалтай болжээ (Зураг 2а). Дуулга тэгш хэм бүхий дугуй хэлбэртэй бөгөөд толгойд өмсөхдөө дотор нь даавуу, арьс зэрэг зүйлээр зөөлөвтэй байсан тухай дурддаг (Конагая Юки 2020: 24). Ооямазүми сүмд бас нэг дуулга хадгалагдаж байдаг байна. Маажиндсан ширэн хамгаалалттай уг дуулга нь 28,5 см өндөртэй, 23 х 22 см хэмжээтэй бөгөөд доод хэсгийг нимгэн төмрөөр

хүрээлж, ширээр их биеийг нь хийсэн ба дөрвөн талдаа урт нарийн төмрөөр барьж, оройд нь хагас дугуй хэлбэртэй төмөртэй холбож бөхөлжээ (Зураг 2б). Нүүрэн талд нүдний хэсэгт хоёр ухсан ба дээр нь багавтар саравчийг төмөр хадаасаар хадаж бөхөлжээ (Конагая Юки 2020: 32). Энэ хоёр дуулгаас гадна “Китано Тэнмагу” хэмээх сүмийн бунхан байрлуулдаг хэсгээс Их Юань гүрний үеийн монгол дайчны төмөр дуулга олдсон талаар “Асахи Шинбүн” сонин мэдээлсэн байдаг (<https://www.asahi.com>). Эл төмөр дуулга Конус хэлбэртэй, 22 см өндөр, 23 см орчим диаметртэй, хоёр килограмм орчим жинтэй бөгөөд гэрэл зургаас үзэхэд нэлэнхүйд нь нимгэн төмрөөр хийсэн бөгөөд хийц загварын хувьд Ооямазүми сүмд хадгалагдаж байгаа дуулгатай яг ижил ажээ (Зураг 2с).

Нум сум. Их Юань гүрний дайчдын зэр зэвсгийн бас нэг гол хэрэгсэл нь нум сум билээ. Монгол улсын нутгаас Юань гүрний үед холбогдох нум сум бүхий зэр зэвсгийн зүйл арвин бий бөгөөд энд цөөн хэдийг төлөөлүүлэн авч үзье. Өвархангай аймгийн Богд сумын нутаг Цагаан хадны оршуулгаас (¹⁴С-ийн шинжилгээгээр 1280-1300 онд холбогддог) суран



Зураг 2. а. Кокүгакүин их сургуулийн музейд хадгалагдаж буй Такашима арлаас олдсон (далайн ёроолд он удаан жил байсан) Юань гүрний үеийн төмөр дуулга, б. Ооямазүми сүмд хадгалагдаж буй төмрөөр хүрээлж, ширээр их биеийг нь хийсэн “ширэн” дуулга, с. “Китано Тэнмагу” хэмээх сүмийн бунхан байрлуулдаг хэсгээс илэрсэн төмөр дуулга



Зураг 3. Их Юань гүрний үеийн малгайтай холбогдох олдвор, түүхэн уран зураг зэрэг баримтуудтай дуулгуудыг харьцуулж үзэхэд “бөмбөгөр оройг 4-6 хэсэгт зааглаж гаргасан загвар, саравч болон шилэвч бүхий хүрээ хэсгүүд ерөнхийдөө адил хийцтэй” байгаа нийтлэг загвар тухайн үеийн малгайнд ч давтагддаг

хөвчтэй зүймэл нум, төмөр зэв бүхий сум, сумыг багцалж бус нэг бүрчлэн хийх зориулалт бүхий гоёмсог хээ чимэглэлтэй арьсан саадаг илэрсэн байдаг (Nomguunsuren *et al.* 2012: 325-349). Уран чимэглэлтэй гоёмсог нумыг Германы эрдэмтэд онцлон анхаарч судалжээ. Хар ба хүрэн өнгийн зурааснуудаар геометрийн дүрс үүсгэж хээлсэн бариулыг нийт арван хэсэг үйсээр хийсэн байх агаад тус бүр тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй эдгээр хэсгүүдээр ромбо маягийн хээ үүсгэжээ. Ийм хар, хүрэн өнгийн зураас бүхий үйсээр бариулын хоёр захыг тойруулан бөгжилсөн байна. Үүний зэрэгцээ бариул ба үүсгэрийг тусгаарлан туузаар хулдсан харагдах бөгөөд тус бүр 1 мм орчим өргөнтэй нийт найман туузыг хоёр талд нь чимэг болгон хэрэглэжээ. Захын хоёр буюу гурван тууз ээлжлэн бараан, эсвэл цайвар өнгөтэй бол голын гурав нь шаталсан олон өнгийн хээтэй байгаа нь яах аргагүй анхаарал татах ажээ. Энд хусны шар үйс, улаан будаг оруулсан үйс, хүрэвтэр үйс, хар будаг оруулсан үйс байх агаад өнгө тус бүрийн


хооронд алтан шармал жижиг дөрвөлжин үйс суулган тусгаарлажээ (Зураг 5a). Эдгээр чимэглэлийн тууз нь гоо зүйн үүднээс төдийгүй технологийн талаас маш сонирхолтой юм. Улаан хэсгийг авч үзвэл үйсэн дээр хар тугалганы исэл, төмрийн исэл бага зэрэг орсон болон мөнгөн усны сульфид агуулсан улаан өнгөтэй гурван төрлийн шороон будгийг хольж дэвсгэрлээд дээрээс нь улаавтар туяатай тунгалагдуу давирхайгаар өнгөлжээ. Энэ бүрхүүл нь хэт ягаан туяанд хөх ягаанаар туяаран харагдана. Гүн хар будгийг мөн үйсэн дээр түрхээд хэт ягаан туяанд ногоорон харагддаг тунгалаг бодисоор давхарлан бүрсэн байна. Энэ өнгөлгөө нь тодорхой тогтоох боломжгүй нэг төрлийн давирхай агаад суурь будаг нь мал, амьтны ясыг шатаан гаргаж авдаг нүүрсэнд хар тугалганы карбонат, хөнгөн цагааны исэл гэх мэт бодисыг бага хэмжээгээр хольсон будаг ажээ. Үйсийг мал, амьтны арьс, яснаас гаралтай цавуугаар наажээ. Археологийн олдворын лабораторийн судалгааны хувьд бас нэгэн шинэлэг зүйл бол шар торгон утсаар оёсон савхин



Зураг 4. Цагаан хадны оршуулгын нум ба түүний “деталь” эд анги



Зураг 5. а. Нумыг чимэглэсэн хээ чимэглэл, б. Уг нумтай хамт илэрсэн “навчин” хэлбэрийн төмөр зэвүүд



Зураг 6. Хагтын хадны оршуулгын нум сум, саадаг

чимэгтэй ширэн саадаг бөгөөд ийм төрлийн саадаг урьд нь зөвхөн дундад зууны уран зурагт дүрсэлсэн байдлаар олдож байсан билээ. Энэ хоромсогын сум бүрийг нэг нэг тусгай нүхэнд шургуулдаг ба нүх болгоны амсрыг хавтгай булан төмрөөр бэхэлсэн ажээ. Эдгээр бэхэлгээ нь ихэд зэвэрч муудсан тул рентген зураг дээр л тодорхой болж харагджээ. Урьд нь ийм олдворыг бүсний чимэг хэмээн үздэг байв. Хамгийн сонирхолтой нь Цагаан хадны оршуулгаас гарсан XIII зууны үеийн сумууд ихээхэн сонирхолтой байжээ. Тэдгээрийн гол хэсгийг хулс, төгсгөлийн хэсгийг хус эсвэл бургасаар (Зураг 5b) хийсэн байсныг модны төрөл тогтоох шинжилгээгээр тодорхой болгожээ (Бемманн нар 2014: 199).

Алтайн нуруунаас олдсон Хагтын хадны оршуулгаас (¹⁴C-ийн шинжилгээгээр 1264-1300 онд холбогддог) эвэр наалттай зүймэл нум, суран хөвчтэйгөө, саадганы дотор сумны зэвийг дээш харуулан дүрсэн 7 сумтай (Зураг 6). Сумнуудыг үндсэн хоёр төрөлд хувааж болно. Үүнд, навчин хэлбэрийн хавтгай иртэй зэв ба конус хэлбэрийн модон булцуут зэв багтдаг (Амартүвшин нар 2020: 119).

Бөхөн уулын оршуулгаас маш сайн хадгалалттай зэр зэвсгийн зүйлс гарсан байдаг. Хоромсогын их биеийг модоор хийсэн ба гадуур нь арьсаар өнгөлсөн. Сэнжний хэсгийг төмрөөр бөхөлжээ. Урт 69 см, өргөн 17 см, зузаан 6 см хэмжээтэй. Хоромсогын их бие модны дээд хэсгийг 13 см урт илүү гарган сум дүрэх амтай. Амсар хэсэгт 2 см өргөн, 0,7 см зузаантай

модыг матаж эмжин хашлага байдлаар урлажээ. Хоромсогыг хар өнгийн арьсаар бүрсэн бөгөөд нүүрэн талын дагууд 0,5 см өргөн товгор чимэглэл, мөн амсрын ирмэг хэсэгт товгор хээ хөөлгөн урласан. Ёроолыг зууван модоор хийсэн. Хоромсогын баруун талд болон амсрын гадна талд оосор бэхлэх зориулалт бүхий жижиг сэнж гаргасан. Үүнээс үзэхэд хоромсогыг баруун ташаандаа зүйж байжээ (Хүрэлсүх нар 2020: 164).

Нумын үндсэн материал нь мод ба эвэр элэг нааж, шөрмөсөөр арлан, үйсээр бүрсэн. Нум 141 см урттай. Нэг талын гичрийн үзүүр хугарч үгүй болсон ба бүтэн хадгалагдсан гичрийн хэсэгт нэмэлт ясан оруулга суулгаж онь хийсэн. Бариул хэсэг 20 см урт, 3,5 см өргөн, 1,8 см зузаантай. Нумын хөвчийг нарийн сурыг эрчилж хийсэн. Хөвчний нэг талын үзүүр тасарч үгүй болсон. Нөгөө талын үзүүр нумын гичирт битүү гогцоо гарган уяж бөхөлсөн байдалтай хадгалагдсан. Хоромсогод яс болон төмрөөр хийсэн зэвтэй 7 сум хадгалагдан үлдсэн (Зураг 7). Эдгээр сумнуудыг мөсөнд суулган, шөрмөсөн утсаар ороосож бөхөлсөн ба мөсний төгсгөлд өдтэй.

Япон улсын Ооямазуми сүмд “халиман сүүлт” хагас нум хадгалагдаж байдаг ба 178 см урт, 3,5 см өргөнтэй ажээ. Уг нумын гэрэл зургаас үзэхэд битүү үйсээр хулдаж байсан халцарч бүдгэрсэн. Бариул хэсэгт өнгө ялган нарийн шаргал өнгийн үйсээр хоёр эгнээ зураас гаргасан нь мэдэгдэнэ (Зураг 8). Мөн төмөр зэвтэй, зэвийг мөсөнд суулгасан ба мөсний




Зураг 7. Бөхөн уулын оршуулгаас илэрсэн арьсаар бүрсэн саадаг, суран хөвчтэй нум, ясан болон төмөр зэвтэй сум



Зураг 8. Ооямазүми сүмд хадгалагдаж буй үйсээр хулдсан нум болон сум



Зураг 9. а. Монголоос олдсон сумны зэв, б. Японд хадгалагдаж буй сум бөгөөд эдгээрийн зэвийг мөсөнд суулгасан байдал, шөрмөсөн утсаар ороосон зэрэг хийцийн ялгаатай байдал харагддаг



Зураг 10. а. Кокүгакүин их сургуулийн музейд хадгалагдаж буй Такашима арлаас олдсон (далайн ёроолд он удаан жил байсан) Юань гүрний үеийн багцалсан сум, б. Дээд Цахир уулын 14-р бушинаас олдсон багц сумны зэв

төгсгөлд 20 орчим см урттай өдтэй. Сумны нийт урт 98,4 см хэмжээтэй ажээ (Конагая Юки 2020: 34-35).

Монгол дахь Юань улсын үеийн булшнаас ихэнхдээ арваад тооны багцалсан сум олддог. Харин Такашима арлаас олдсон сумыг (Икэда Эйжи 2024: 35) багцалсан байдлаас үзэхэд тооны хувьд хамаагүй олон тоотой байх ба энэ нь мэдээж (далайд байлдах тул) зэвсгийн нөөцтэй ихээхэн хамааралтай байна.

Илд. Монгол дайчдын дайн байлдааны үед голлон хэрэглэдэг сэлэм XIII-XIV зууны үеийн булшнаас цөөнгүй олдсон байдаг. Тухайлбал, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Норзод хайрхан хэмээх газрын нэгэн булшнаас махирдуу үзүүртээ төмөр сэлэм илэрсэн (Энхтөр нар 2022: 26). Уг сэлэм 66 см урт, 3.6 см өргөнтэй. Хурц үзүүр, нэг талдаа иртэй ба бариул хэсэгт гар хамгаалсан зууван хэлбэрийн

хавтгай төмөр хамгаалалттай. Бариулын угт төмрөөр балтаг гаргасан (Зураг 11).

Монгол цэргийн музейн сан хөмрөгт нэгэн илд хадгалагдаж байдаг байна. Энэхүү илдийг 1984 онд Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутгаас олж тус музейд хүлээлгэн өгчээ. Хотгор илдний урт нь 80,7 см, өргөн нь 3.7 см, жин нь 800 гр жинтэй бөгөөд бариулнаас дээш илдний угт урт нь 8.1 см, өргөн нь 1.6 см-ийн талбайд давхиж байгаагаар чонын дүрсийг хоёр талд нь бодит бус байдлаар загварчлан, уран чадварлагаар товойлгон сийлсэн байдаг (Зураг 12). Хотгор илд нь хурц үзүүртэй, цавчихад нэг их хүч шаардахгүйгээр далайсан хүчээрээ үзүүр хүртэл зүсэн өнгөрдөг онцлогтой охор зэвсэг ажээ. Охор зэвсэг гэдэг нь байлдан тулалдах явцад гараас салгалгүйгээр хатгалдан цавчилдах зориулалттай илд, жад, хутга,



Зураг 11. Булинаас төмөр сэлэм илэрч буй нь



Зураг 12. Монгол цэргийн музейд хадгалагдаж буй XIII-XIV зууны үеийн “хотгор” илд



Зураг 13. Такашима арлын орчмоос хоёр сэлэм олдсон ба тэдгээрийн нэг болох “махир” сэлэм

бялуу, сүх тэргүүтэн зэвсгийг хэлдэг байна. Илдний хөнгөн, хурц иртэй байгаа нь төмрийн хатаалт сайтай байгааг илтгэдэг бөгөөд Монгол дархчууд илдийг давтаж хатаахдаа салхин хат, давс хүчлийн хат, эвэр туурайны хат, зунгаг үс ноосны хат гэх мэт олон төрлийн аргаар төмрийг хатааж маш даацтай, хурц илд хийдэг уламжлалтай байжээ.

Их Юань гүрний үеийн төмөр сэлэм Япон улсын Такашима арлын орчмоос хоёр сэлэм олдсон ба уг сэлэм хуй, бариултай байсан бөгөөд тэнгисийн ёроолд удаан хугацаагаар байсан учир дээрх дуулгын төмрийн адил хөөж, анхны хэлбэрээ алджээ (зураг 13). Хадгалан хамгаалах үйл ажиллагааны үед хуйны үлдэгдэлд хийсэн модны судалгаагаар түүнийг ялмын төрлийн модоор хийсэн гэж үзсэн бөгөөд Японд сэлэмний хуй хийхдээ ийм төрлийн модыг хэзээ ч ашигладаггүй байна. Иймд эдгээр сэлмийг Японд хийгээгүй, харин Монголын сэлэм байжээ хэмээн таамагладаг ажээ (Конагая Юки 2020: 26-27). Уг сэлэмийн үзүүр хугарч алга болсон ба урт нь 64.5 см, үүнээс сэлэмний ир 52 см, зузаан 0.7 см хэмжээтэй.

Монголоос олдсон эдгээр зэр зэвсэг нь ихэнхдээ морьтон дайчинд зориулсан авч явахад хөнгөн

авсаархан байдал, ойр болон холын зайд орших байг хөнөөх чадвар зэргээрээ гойд байсан нь монголчуудын дундад зууны үед явуулсан олон удаагийн дайн байлдааны амжилтад ихээхэн нөлөө үзүүлж байжээ.

Дүгнэлт

Монгол улс болон Япон улсад өнөө цагт хадгалагдаж байгаа Их Юань гүрний үеийн цэрэг дайчдын зэр зэвсгийн зарим зүйлсийг бага боловч харьцуулан авч үзлээ. Их Юань улсын түүхийг судлан шинжлэхэд Хубилай сэцэн хааны Япон улсад довтолсон усан флоттой холбогдох олдвор, эх хэрэглэгдэхүүнийг бидний зүгээс анхаарч, өдий хүртэл тоймтойхон харьцуулан судалгаа хомс байдаг нь анзаарагдаж байна. Юуны түрүүнд дайчин эрсийн “дуулга” малгайны материал, хэлбэр хэмжээ, хийц технологийн хувьд тун адил төстэй байгааг археологийн биет олдворууд тодорхой харуулж байгаа хэдий ч Япон улсын Ооямазүми сүмд хадгалагдаж буй төмрөөр хүрээлж, ширээр их биеийг нь хийсэн “ширэн” дуулга, “Китано Тэнмагу” хэмээх сүмийн бунхан байрлуулдаг хэсгээс илэрсэн төмөр дуулгуудын

саравч зэргийг үзэхэд Юань улсын үе гэхээсээ илүүтэй Мин улсын үед хамаарч магадгүй юм.

Нум сумны тухайд харьцангуй бүрэн бүтэн байгаа тул харьцуулан авч үзэх боломжтой. Монголоос олдсон Их Юань улсын үед холбогдох Цагаан хадны оршуулгын нумын урт 124 см урт, Хагтын хадны оршуулгын нумын урт 121 см, Бөхөн уулын хадны оршуулгын нум 144 см урт, Ёлын хэцийн оршуулгаас илэрсэн (Цэлхагарав нар 2020: 171) нумын урт 93.5 см хэмжээтэй бол Оямазуми сүмд хадгалагдаж буй үйсээр хулдсан нумын урт 178 см хэмжээтэй ажээ. Эдгээр нумуудыг хэрхэн яаж хэмжсэн талаар тодорхой мэдэх боломжгүй ч Японд хадгалагдаж буй нум Монголд байгаа нумаас 30-50 орчим см урт хэмжээтэй хэмээн үзэж болохоор байна. Энэ нь магадгүй морин дээрээс бус харьцангуй хөдөлгөөн багатай суурин байдлаар ашиглахад дөхөм байх ба сум илүү хол тусгахтай холбоотой байж болох юм. Мөн Бөхөн уулын оршуулгаас илэрсэн сумын урт дундаж нь 77 см, Ёлын хэцийн сум 79 см урт, Хагтын хадны оршуулгын хамгийн урт сум нь 81 см хэмжээтэй. Харин Оямазуми сүмд хадгалагдаж буй төмөр зэвтэй бүтэн 4 сум нь 98.4 см урттай ажээ. Энэ нь том хэмжээний нумтай учир сум мөн адил уртхан байх шаардлагатай болжээ. Түүнчлэн Японд хадгалагдаж буй төмөр зэвтэй суманд шөрмөсөн утас хэрэглээгүй байгаа нь “сумыг суурин газарт их хэмжээгээр үйлдвэрлэх явцад гар ажиллагаа шаардагддаг олон шат дамжлагыг багасгах үүднээс шөрмөсөн утсаар ороох нарийн деталь ажлыг хялбаржилж, зэвийг урт сурвалжтай хийн мөсөнд лавхан суулгажээ” (Зураг 9) хэмээн үзэхээр байна. Харин төмөр сэлмийн уртын хэмжээнүүд ойролцоо байгаас өөрөөр нарийвчлан өгүүлэх хэрэглэгдэхүүн дутмаг байна.

Цаашид эдгээр болон дахин шинээр илрэх боломжтой эд өлгийн зүйлсийн материалын төрөл, орц найрлага, хийц технологи, зарим олдворын үүрэг зориулалтыг хамтын хүчээр тодорхойлон, лавшруулан судлах, анхны эх загвараар сэргээн засварлахдаа Монгол болоод бусад улс орон дахь адил төстэй олдворуудтай харьцуулах зэрэгт ихээхэн үр дүнтэй, ач холбогдолтой ажил болно хэмээн үзэж байна.

Abstract

Comparison of Great Yuan period weapon finds in Mongolia and Japan

Sosorbaram Khurelsukh

The study of the history of the Great Yuan, one of the constituent states of the Mongol Empire, reveals significant insights into the military campaigns of Khubilai Khan,

including the invasion that targeted Japan. Recent marine archaeology research and conferences held in Japan underscore the importance of archaeological artifacts and primary sources in advancing our understanding of this era. This article presents a comparative analysis of artifacts from the Great Yuan period (1264-1368) preserved in both Mongolia and Japan. The research focuses on the weapons and tools discovered in burial sites across Mongolia, examining them alongside similar items housed in Japan. The findings of this comparative study contribute to our understanding of the cultural and material exchanges between these regions during the Great Yuan period.

Keywords: Weapons of Mongolian warriors, Great Yuan, Mongolia, Japan

Ном зүй

Амартүвшин, Ч., Батдалай, Б. (2020). Хагтын хадны оршуулга. Нүүдэлчдийн өв судлал. Tomus XXI-II, Fasc-11: 110-127.

Базарсүрэн, Ж. (2006). Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ.

Икэда Эйжи (ред). (2024). Kokugakuin University Museum special exhibition. Underwater Archaeology Reveals the Mongolian Invasion. Published by Kokugakuin University Museum. September 21, Tokyo.

Конагая Юки (ред). (2020). “Генко” буюу Монголын довтолгоонд холбогдох материалыуд. Япон дахь Монголын түүхэнд холбогдох соёлын дурсгалт зүйлс. УБ.

Худяков, Ю.С. (2007). Непобедимая армия монголов. Наука из первых рук. №1(13) Изд: «ИНФОЛИО». Новосибирск: 28-37.

Хүрэлсүх, С., Амгаланбаатар, Б. (2020). Санамсаргүй хөндөгдсөн нэгэн хадны оршуулга. Studia Archaeologica. Instituti Archaeologici Academiae Scientiarum Mongolicae. Tomus XXXIX, Fasc-16: 162-169.

Цэлхагарав, Ц., Бемманн, Я., Төрбат, Ц. (2020). Ёлын хэцийн хадны оршуулга. Studia Archaeologica. Instituti Archaeologici Academiae Scientiarum Mongolicae. Tomus XXXIX, Fasc. 17: 170-184.

Энхтөр, А., Батбалд, Г., Буянхишиг, Ц. (2022). Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Норзод хайрханд ажилласан судалгааны ажлын тайлан. АХГБСХ

Эрдэнэ-Очир, Н. (2014). Дундад зууны нүүдэлчдийн зэр зэвсэг. Талын морьтон дайчдын өв соёл. УБ: 95-107.

Ян Бемманн, Михаэль Шмаудер. (2014). Монголын хадны оршуулгын эд өлгийг хамгаалах байгалийн шинжлэлийн үүднээс судлах төсөл. “Талын морьтон

дайчдын өв соёл” каталог. УБ: 195-201.

Josef Kreiner. (2005). Die mongolischen Versuche einer Unterwerfung Japans. Dschingis khan und seine erben. Das weltreich der Mongolen. München, Kunst- und Ausstellungshalle der Bundesrepublik Deutschland, 2005: 328-337.

Nomguunsuren, G., Ahrens, B., Piezonka, H. (2012). Die Hoehlengrab von Cagaan Chad, Bogd Sum, Oevoerchangaj Ajmag. Steppenkrieger: Reiternomaden des 7.-14. Jahrhunderts aus der Mongolei. Eine

Ausstellung im LVR – Landes Museum Bonn. Primus Verlag, Darmstadt. 2012: 325-349.

Received: Oct. 20, 2024; Revised: Nov. 17, 2024; Accepted: Dec. 16, 2024

